



НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Төвийн даргын дэргэдэх орон тооны бус
Зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 117 дугаартай тогтоолоор баталсан төвийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7, төвийн даргын 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/10 дугаартай тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төвийн даргын дэргэд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга	Төвийн дарга
Зөвлөлийн гишүүд	Ахлах аргазүйч Нягтлан бодогч Сэтгэлзүйч Төсөл хөтөлбөр хариуцсан нийгмийн ажилтан Эмч
Нарийн бичгийн дарга	Ахлах нийгмийн ажилтан

2.Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцож, түүний биелэлтэнд хяналт тавин ажиллахыг зөвлөлийн гишүүдэд анхааруулсугай.

3.Даргын дэргэдэх зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтийг хангуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг зөвлөлийн нарийн бичигт үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/19 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА *М. Мөнхцэцэг* Ш.МӨНХЦЭЦЭГ



318060092